БАТЛАВ
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
С.МӨНХЧУЛУУН

ДУНДГОВЬ АЙМГИЙН ГУРВАНСАЙХАН СУМЫН ТӨВӨӨС ЧОЙР-МАНДАЛГОВЬ-АРВАЙХЭЭР ЧИГЛЭЛИЙН ХЭВТЭЭ ТЭНХЛЭГИЙН АВТО ЗАМТАЙ ХОЛБОГДОХ 47 КМ АВТО ЗАМЫН ИНЖЕНЕРИЙН НАРИЙВЧИЛСАН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2025 оны 10-р сарын 17-ны өдөр Дугаар: 61/2025 Мандалговь хот

1	Зураг төсөл боловсруулах үндэслэл	- Дундговь аймгийн хөгжлийн бодлого стратеги төлөвлөгөө /2012-2031 он/-нд тусгагдсан. /1.1.1.9. Босоо болон хөндлөн тэнхлэгийн замд ойрхон сумдын төвийг эдгээртэй салаа замаар холбох/.
2	Байршил	Дундговь аймгийн Гурвансайхан сум;
3	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	Орон нутгийн хөгжлийн сан;
4	Авто замын техникийн ангилал, замын зэрэг	Төв замын сүлжээн дэх гол зам бөгөөд зорчих хэсэг нь заагдаагүй, хөдөлгөөний 2 зурвастай, тооцоот хурд нь 80 км/цаг;
5	Замын эхлэл цэг	Гурвансайхан сумын төв;
6	Замын төгсгөлийн цэг	Чойр-Мандалговь-Арвайхээр чиглэлийн хэвтээ тэнхлэгийн авто зам хүртэл;
7	Замын хучилтын хийц	Асфальт бетон хучлага, цементээр бэхжүүлсэн суурь, байгалийн тохиромжтой материал бүхий суурийн доод үе бүхий хучилтын ерөнхий хийцийг техникийн шийдэл ба тооцоогоор сонгох;
8	Төлөвлөлтийн норм	- "Авто зам төлөвлөх" ЗЗБН Д 22-004-2016, - "Авто замын гүүр ба хоолой төлөвлөх" БНбД32-02-12 - "Хот суурины гудамж зам төлөвлөлт" БНбД 32-01-04 - "Авто замын уур амьсгал, геотехникийн нөхцөл АЗУАГН 2.01.01-2004 - "Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх" БНбД - "Барилга байгууламжийн инженерийн судалгааны нийтлэг үндэслэл" БНбД 11-07-04-ийн II хэсэг инженер геодезийн ажил, "Геодезийн ажил" БНбД 3.01.03-88 - "Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага" MNS4596:2014 - "Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм" MNS4596:2014 - "Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн нормаль" БД31-101-04, - Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар" MNS 6056:2009;
9	Зураг төсөл зохиох үе шат, хугацаа	1 үе шаттай, 2025 он;
10	Зураг төслийн иж бүрдэл	• Байр зүйн хэмжилтийн ажлын тайлан; • Инженер геологийн судалгааны ажлын тайлан; • Авто замын уртад техник ашиглалтын түвшингийн судалгаа далан, суурьнд ашигласан материалын судалгааны дүн, замын эвдрэлийн шалтгааныг тогтоосон дүгнэлт;

		• Одоо байгаа төмөрбетон гүүр болон хиймэл байгууламжийн хийц, ашиглалтын байдлын судалгааны дүгнэлт; • Дараах хэсгүүдийг нэгтгэсэн авто замын ажлын иж бүрэн зураг төсөл. - Авто зам, хиймэл байгууламж, гүүрийн ажлын иж бүрэн нарийвчилсан зураг төсөл; - Зам, замын байгууламжийн барилгын ажлын техникийн шаардлага; - Зам гүүрийн зурваст сонгосон инженерийн байгууламж, цахилгаан, холбооны шугам сүлжээний техникийн нөхцөлийг холбогдох байгууллагуудаас авах, шаардлагатай тохиолдолд нүүлгэн шилжүүлэх, засварлах, өндөрсгөх ажлын тоо хэмжээ, зардал; - Ажилбар тус бүрийн болон Барилгын ажлын нэгдсэн тоо хэмжээ; - Инженерийн дэлгэрэнгүй тайлан (ИДТ); - Замын барилгын ажилтай холбоотой газар олгосон орон нутгийн засаг захиргааны захирамж болон бусад зөвшөөрөл, техникийн нөхцөлүүд; - Том оврын тээврийн хэрэгслийн зогсоолын талбайн зураг төсөл; - Зураг төслийн иж бүрдэл тус бүрийг баталгаажуулсан магадлалын ерөнхий дүгнэлт; <u>Зураг төсөлд тавигдах шаардлага:</u> Зураг төслийг хот байгуулалтын мэдээллийн санд хүлээж авахад тавигдах шаардлага. а. Хот байгуулалтын мэдээллийн сангийн стандартыг мөрдөх; б. Хийгдэж буй төслийн дэвсгэр зургийн WGS-848 UTM буюу солбицлын нэгдсэн тогтолцоонд хийж гүйцэтгэх;
11	Зураг төслийн байгууллага	“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн дагуу сонгогдон шалгарсан хуулийн этгээд;
12	Захиалагч байгууллага	Дундговь аймгийн Засаг даргын тамгын газар;
13	Онцгой нөхцөл	- Уулзвар гарц, одоо байгаа замын огцом налуу болон эргэлт бүхий хэсгүүд зэрэг хэсгүүдийн хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах, цогц арга хэмжээг төсөллөх; - Ухмал ба зам дээр цас хунгарлахаас сэргийлэх инженерийн шийдлийг төсөллөх; - Халиа, дошин, үер, уруйгаас хамгаалах байгууламжийг төсөллөх; - Мал, амьтны зам хөндлөн гарах магадлал бүхий цэгүүдийг судалгаагаар тогтоож, мал амьтан авто зам хөндөлн гарах гарц төсөллөх; - Замын шаардлагатай хэсэгт түр зогсоол төсөллөх; - Газар хөдлөлтөөс үзүүлэх нөлөөллийг тооцох; - Замын барилгын ажлын явцад тээврийн хөдөлгөөнийг саадгүй явуулах түр замын ажлын хэмжээг гаргаж, зураг төсөлд хавсаргах; - Замын хөдөлгөөн зохион байгуулалт, тоноглолын зураг төслийг нарийвчлан боловсруулж, хөдөлгөөний аюулгүй байдалд аудит хийлгэх;

		- Авто замын трасст орсон нүүлгэн шилжүүлэх шаардлагатай барилга байгууламжийн зураг төсөл, тооцоог гаргаж ИДТ-д тусгах; - Зургийн байгууллага хариуцлагын даатгалд даатгуулсан байна; - Инженерийн нарийвчилсан зураг төслийн иж бүрдлийг захиалагч болон бусад байгууллагаар хянуулж зөвшилцсөний дараа магадлалд хамруулах; - Авто замын төлөвлөлтийг огтлолцож буй болон холбогдож буй бүх талын замын төлөвлөлттэй уялдуулах.
14	Зөвшилцөх байгууллага	Дундговь аймгийн ЗДТГ, ГХБХБГ, аймгийн Ерөнхий архитектор, Гурвансайхан сумын ЗДТГ, цахилгаан, холбоо зэрэг инженерийн шугам сүлжээний хангагч байгууллагууд;

ЗӨВШӨӨРСӨН:

АЙМГИЙН ЗДТГ-ЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ — Б.ЛХАГВАБААТАР

ГУРВАНСАЙХАН СУМЫН ЗАСАГ ДАРГА — Б.ЭНХТУЯА

ХЯНАСАН:

АЙМГИЙН ЗДТГ-ЫН ХБТХОХ-ИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН — Ж.УЯНГА

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА — Э.ЧАГНААДОРЖ

БОЛОВСРУУЛСАН:

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА — Э.ЭНХМЭНД

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН — Б.БАЗАРЛХАГВА